

UCS 0801C:2022

## НОГООН БАЙГУУЛАМЖ




Цэцэрлэгчийн хөдөлмөрийн багаж хэрэгсэл,  
машин тоног төхөөрөмжийн лавлах



# НОГООН БАЙГУУЛАМЖ

Цэцэрлэгчийн хөдөлмөрийн багаж хэрэгсэл,  
машин тоног төхөөрөмжийн лавлах

*Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2022 оны 20-р тогтоолоор батлав.*



## ГАРЧИГ

1. Хамрах хүрээ .....	4
2. Норматив эшлэл.....	4
3. Нэр томъёоны тодорхойлолт.....	5
4. Цэцэрлэгжүүлэлтийн багаж, хэрэгсэл, машин, тоног төхөөрөмж .....	5
4.1 Хөрс боловсруулалтад ашиглагдах үндсэн техник, багаж, хэрэгслүүд .....	6
4.2. Зүлэгжүүлэлтийн ажилд шаардлагатай багаж, тоног төхөөрөмжүүд.....	8
4.3 Зүлэгт талбайг арчлан хамгаалахад шаардлагатай багаж, хэрэгсэл.....	10
4.4 Цэцэгт байгууламжийн арчилгаанд ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд .....	12
4.5 Мод, сөөгийн тарилтад ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд .....	14
4.6 Мод, сөөгийн арчилгаанд ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд .....	14
4.7 Мод, сөөгийн хэлбэржүүлэлтэнд ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд .....	16
4.8. Мод, сөөгийг шилжүүлэн суулгахад ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд.....	19
4.9 Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтэд ашиглагдах усалгааны тоног төхөөрөмжүүд, машин механизм .....	20
4.10 Ногоон байгууламжийн өвчин, хортонтой тэмцэхэд ашиглагдах багаж, хэрэгсэл .	22
Ашигласан материалын жагсаалт .....	23

### ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 8. Талбайн хөрс боловсруулалт (Жишээ зураг).....	8
Зураг 32. Үрийг гараар нэгэн жигд цацах (Жишээ зураг) .....	12
Зураг 33. Үрийг механизмаар цацах (Жишээ зураг) .....	12
Зураг 34. Зүлгийн тайралт, арчилгаа (Жишээ зураг) .....	12
Зураг 68. Мод, сөөгийг хэлбэржүүлэх (Жишээ зураг) .....	18

### ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Хөрс боловсруулалтад ашиглагдах үндсэн техник, багаж, хэрэгслүүд.....	6
Хүснэгт 2. Зүлэгжүүлэлтийн ажилд ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд.....	8
Хүснэгт 3. Зүлэгт талбайг арчлан хамгаалахад шаардлагатай багаж, хэрэгсэл .....	10
Хүснэгт 4. Цэцэгт байгууламжийн арчилгаанд ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд....	12
Хүснэгт 5. Мод, сөөгийн тарилтад ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд.....	14
Хүснэгт 6. Мод, сөөгийн арчилгаанд ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд.....	15
Хүснэгт 7. Мод, бут сөөгийн хэлбэржүүлэлтэд ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд....	17
Хүснэгт 8. Мод, бут сөөгийн шилжүүлэн суулгахад ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд .....	19
Хүснэгт 9. Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтэд ашиглагдах усалгааны тоног төхөөрөмжүүд, машин механизм .....	20
Хүснэгт 10. Ногоон байгууламжийн өвчин хортонтой тэмцэхэд ашиглагдах багаж, хэрэгсэл .....	22



**НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 04 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

Ногоон байгууламжид хамаарах  
хотын стандартыг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт; Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэг, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10<sup>1</sup> дүгээр зүйлийн 10<sup>1</sup>.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах эрхийг хангахад чиглэсэн Ногоон байгууламж бүлэгт хамаарах дор дурдсан стандартуудыг хавсралтаар баталсугай. Үүнд:

1.1. UCS0801A:2022 “Хот суурин газрын цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн төлөвлөлтийн удирдамж” хотын стандарт

1.2. UCS0802C:2022 “Мод таримал ургамлын төрөл зүйлийн лавлах” хотын стандарт

1.3. UCS0803B:2022 “Ногоон байгууламжийн арчилгаанд тавих шаардлага” хотын стандарт


1.4. UCS0802A:2022 “Цэцэрлэгчийн хөдөлмөр аюулгүй ажиллагааны удирдамж” хотын стандарт

1.5. UCS0801C:2022 “Цэцэрлэгчийн хөдөлмөрийн багаж хэрэгсэл, машин тоног төхөөрөмжийн лавлах” хотын стандарт

2. Батлагдсан хотын стандартуудыг мөрдүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д даалгасугай.


3. Энэхүү тогтоолыг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

ДАРГА



Ж. БАТБАЯСГАЛАН

1115100357



Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 20.  
дугаар тогтоолын тавдугаар хавсралт

## НОГООН БАЙГУУЛАМЖ

### UCS 0801C:2022 “ЦЭЦЭРЛЭГЧИЙН ХӨДӨЛМӨРИЙН БАГАЖ ХЭРЭГСЭЛ, МАШИН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЛАВЛАХ” ХОТЫН СТАНДАРТ

#### 1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү стандартыг цэцэрлэгжүүлэлтийн үйл ажиллагаа явуулдаг иргэн, аж ахуй нэгж байгууллага дагаж мөрдөнө.

#### 2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү стандартад эш татсан дараах барилгын норм ба дүрэм, стандартын шаардлагыг хангах ба өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалыг үндэслэл болгоно.

- MNS 6139:2010 Шилмүүст төрлийн модны суулгац. Техникийн шаардлага.
- MNS 6141:2010 Навчит төрлийн модны суулгац. Техникийн шаардлага.
- MNS 2418:2011 Мод үржүүлгийн газрын хөрсийг боловсруулах. Ерөнхий шаардлага.
- MNS 6253-1:2011 Мод сөөгийн үрийг тарихад бэлтгэх- Ерөнхий шаардлага
- MNS 6253-2:2011 Мод сөөгийн үр тарих. Ерөнхий шаардлага
- MNS 6253:2011 Мод сөөгийн үр тарьсны дараа арчлах -Ерөнхий шаардлага
- MNS 6254:2011 Мод сөөгийн суулгацыг бойжуулах -Ерөнхий шаардлага
- MNS 6256:2011 Сөөгөнцрийн суулгац- Ерөнхий шаардлага
- MNS 6257:2011 Улиасны суулгац -Ерөнхий шаардлага
- MNS 6258-1:2011 Суулгацын нүхийг бэлтгэх, суулгах.- Ерөнхий шаардлага
- MNS 6258-2:2011 Мод сөөгийн суулгац арчлах
- MNS 6259:2011 Ганц наст цэцэг тарих арга
- MNS 6260:2011 Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах
- MNS 6772:2019 Мод сөөгийг хэлбэржүүлэх - Техникийн шаардлага
- MNS 6773:2019 Сөөгийн суулгацыг шилжүүлэн суулгах, арчлах -Техникийн шаардлага
- MNS 6774:2019 Том мод, суулгацыг шилжүүлэн суулгах, арчлах
- MNS 5623:2006 Хөлийн хамгаалалт ажлын ажлын тусгай гутал
- MNS 4931:2000 Хөдөлмөрийн хамгааллын хэрэгсэлд тавих ерөнхий шаардлага

### 3. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

**Суулгац** - гэж бойжуулах талбайд шилжүүлэн суулгаж ургуулсан 2-оос дээш настай модлог ургамал;

**Тайралт** - гэж мод, эрхтэн (үндэс, иш, навч, цэцэг гэх мэт)-ийн тодорхой хэсгийг богиносгох эсвэл сийрэгжүүлэх арчилгаа;

### 4. ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН БАГАЖ, ХЭРЭГСЭЛ, МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

Цэцэрлэгчийн ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгсэл нь “MNS 4931:2000 Хөдөлмөрийн хамгааллын хэрэгсэлд тавих ерөнхий шаардлага” стандартын үзүүлэлт шаардлагыг бүрэн хангах бөгөөд нэмэлтээр заасан дараах шаардлагуудыг хангасан байна.

Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагуудын тохижилт цэцэрлэгжүүлэлтийн ажилд ашиглах хөдөлмөрийн чухал шаардлагатай багаж хэрэгсэл, машин, тоног төхөөрөмжийг ерөнхий ашиглалт, зориулалтаар нь дараах байдлаар ангилсан. Үүнд:

- цэцэрлэгчийн ажлын хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэл;
- хөрс боловсруулалтад ашиглагдах үндсэн техник, багаж, хэрэгслүүд;
- зүлэгжүүлэлтийн ажилд шаардлагатай багаж, тоног төхөөрөмжүүд;
- зүлэгт талбайг арчлан хамгаалахад шаардлагатай багаж, хэрэгсэл;
- цэцэгт байгууламжийн арчилгаанд ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд;
- мод, сөөгийн арчилгаанд ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд;
- мод, сөөгийн хэлбэржүүлэлтэд ашиглах багаж, тоног төхөөрөмж;
- хот тохижилтын цэвэрлэгээ, арчилгаанд ашигладаг багаж;
- мод, сөөгийн шилжүүлэн суулгахад ашиглагдах багаж тоног төхөөрөмжүүд;
- ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтэд ашиглагдах усалгааны тоног төхөөрөмжүүд, машин механизм;
- ногоон байгууламжийн өвчин, хортонтой тэмцэхэд ашиглагдах багаж, хэрэгсэл.

## 4.1 Хөрс боловсруулалтад ашиглагдах үндсэн техник, багаж, хэрэгслүүд

Хүснэгт 1. Хөрс боловсруулалтад ашиглагдах үндсэн техник, багаж, хэрэгслүүд

Техник хэрэгслийн нэр	Зориулалт, ашиглалтын шаардлага	Хэрэглэх үеийн аюулгүй ажиллагаа
 <p><i>Зураг 1. Жижиг трактор (Жишээ зураг)</i></p>	<p>Мод тарих, хөрс боловсруулах, арчилгааны ажлуудын үед хөдөлгүүрүүдийг холбож цэцэрлэгийн хөдөлмөр хэмнэнэ. Үйлдвэрээс өгсөн зөвлөмжийн дагуу ашиглалт, зориулалтаар хэрэглэнэ.</p>	<p>Үндсэн трактортой ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгааг авсан байна. Тракторт холбох хөдөлгүүр тус бүр дээр ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөнө. Хөдөлгүүр тус бүрийн тохиргоо, ажлын дарааллыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу дагаж мөрдөнө. Жижиг трактор жолоодогч нь жолоодох эрх бүхий ангилалтай үнэмлэхтэй байна. Тракторын жолооч нь аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж доргилтын хамгаалалттай бүс, хөдөлмөр хамгаалах хувцас, хэрэглэлтэй байна.</p>
 <p><i>Зураг 2. Явган трактор (Жишээ зураг)</i></p>	<p>Бага орон зайд, том оврын техник ажиллах боломжгүй, техник тоног төхөөрөмжийн хязгаарлалттай орчинд явган тракторыг ашиглана.</p>	<p>Жижиг трактор болон явган тракторт угсарч хөрсийг хагална. Анжсаар атар газрыг хагалж хөрс боловсруулахад ашиглана.</p>
 <p><i>Зураг 3. Анжис (Жишээ зураг)</i></p>	<p>Жижиг трактор болон явган тракторт угсарч хөрсийг хагална. Анжсаар атар газрыг хагалж хөрс боловсруулахад ашиглана.</p>	<p>Жижиг трактор болон явган тракторт угсарч хэрэглэх үед жолоодогч нь мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээтэй байх ба хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг баримтална. Хөрс боловсруулах анжсыг тракторт бат бэх холбосон байх хэрэгтэй.</p>



<p>Сийрүүлэгч</p>  <p>Зураг 4. Сийрүүлэгч (Жишээ зураг)</p>		
 <p>Зураг 5. Сийрүүлэгч (Жишээ зураг)</p>	<p>Бүх төрлийн хөрсийг буталж боловсруулна.</p> <p>Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлт хийх талбайн хэмжээнээс хамаарч хөрсийг боловсруулахад ашиглана.</p> <p>Үйлдвэрээс өгсөн зөвлөмжийн дагуу ашиглалт, зориулалтаар хэрэглэнэ.</p>	<p>Цэцэрлэгчийн ажилд ашиглагдах моторт хөдөлгүүр, тоног, төхөөрөмжтэй ажиллах ажилтан нь мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээтэй байх ба хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг баримтална.</p> <p>Машин механизм, тоног төхөөрөмжийг ажилд бэлтгэх, гарахын өмнө бүрэн бүтэн байдлыг шалгах.</p>
 <p>Зураг 6. Сийрүүлэгч (Жишээ зураг)</p>		<p>Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл өмсөнө.</p>
 <p>Зураг 7. Борной (Жишээ зураг)</p>	<p>Хөрний гадаргууг жигд бутлаж, тэгшлэх, зориулалттай.</p>	<p>Жижиг трактор болон явган тракторт угсарч хэрэглэх үед жолоодогч нь мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээтэй байх ба хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг баримтална. Хөрс боловсруулах борнойг тракторт бат бэх холбосон байх хэрэгтэй.</p>



Зураг 8. Талбайн хөрс боловсруулалт (Жишээ зураг)

#### 4.2. Зүлэгжүүлэлтийн ажилд шаардлагатай багаж, тоног төхөөрөмжүүд

4.2.1. Зүлэгжүүлэлтийн ажилд зүлэг үрлэх, үр бордоо цацах, хөрсний гадаргууг нягтруулах зэрэг ажлуудад ашиглагдах багаж хэрэгслүүдийн зориулалтын ерөнхий зааврыг хүснэгт 2 -т оруулав.

Хүснэгт 2.Зүлэгжүүлэлтийн ажилд ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд

Техник хэрэгслийн нэр, ашиглалт	
<p><b>Зүлгийн үрлэгч</b></p> <p>Их хэмжээний талбайг үрлэх боломжтой. Зүлгийн үр тарих зориулалтаар ашиглана.</p>  <p>Зураг 9. (Жишээ зураг)</p>	<p><b>Зүлгийн үрлэгч</b></p> <p>Зүлгийн үр тарих, зүлгийг тайрах, тэгшлэх зэрэг зориулалтаар ашигладаг олон талт машин. Зөөврийн болон халгалах зориулалттай.</p>  <p>Зураг 10. (Жишээ зураг)</p>
<p><b>Үр, бордоо цацагч</b></p> <p>Бага хэмжээний талбайн зүлэгжүүлэлтэд үрийг үрлэх, бордоо цацах зориулалтаар ашиглана.</p>  <p>Зураг 11. (Жишээ зураг)</p>	<p><b>Гар үр, бордоо цацагч</b></p> <p>Зүлэгний үрийг үрлэх, бордоо цацах зориулалтаар ашигладаг.</p>  <p>Зураг 12. (Жишээ зураг)</p>

**Гадаргуу тэгшлэгч**

Хөрсний гадаргууг тэгшлэх, нягтруулах, зүлэгний үрийг хөрсөнд шигтгэж өгөх зориулалттай.



Зураг 13.(Жишээ зураг)

**Тармуур**

Хөрсийг самнаж тэгшлэх, няцалж, бутлах, ургамлын мөр хоорондын хөрсийг сийрүүлэх, талбайн өвс, ургамал, чулуу зэргийг самнаж, түүж, цэвэрлэх зэрэг олон төрлийн ажлыг гүйцэтгэх зорилгоор ашиглана.



Зураг 14.(Жишээ зураг)

**Малтуур**

Сулласан шороог нааш цааш нь малтаж, засаж тэгшлэх, хог ургамал чулуу зэргийн малтаж цэвэрлэх зориулалтаар ашиглана. Хөрсийг бутлах, тэгшлэх, хайрцаг хийх, шан татах, сэндийлэх гар цавчуур юм. Шигүү таригдсан ургамлын мөр хоорондын хөрсийг сийрүүлэх зорилгоор ашиглана.



Зураг 15.(Жишээ зураг)

**Хүрз гурвалжин**

Цэцэрлэгийн хөрсийг хагалж тэгшлэн, няцалж бутлах, засах олон төрлийн ажлуудыг гүйцэтгэх зорилгоор ашигладаг. Хүнд шавранцар хөрсийг хурц үзүүртэй шөвгөр хүрзээр хагалж боловсруулна.



Зураг 16.(Жишээ зураг)

**Хүрз дөрвөлжин**

Хөрсийг ачиж тээвэрлэх, буулгах, сул хөрсөнд ашиглах зориулалттай. Хөнгөн хөрсийг дөрвөлжин хүрзээр хагалж боловсруулах нь тохиромжтой байдаг.



Зураг 17.(Жишээ зураг)

**Жоотуу**

Хөрс шороог ухах, хагалахад зориулагдсан гар хэрэгсэл юм. Хатуу хөрс, чулуурхаг газрыг хагалах, нүх ухахад ашиглаж болно.



Зураг 18.(Жишээ зураг)

<p style="text-align: center;"><b>Сэрээ</b></p> <p>2-3, 4-5 ширхэг шүдтэй сэрээгээр хагалсан шороог сийрүүлэх болон бусад цэцэрлэгжүүлэлтийн ажилд хэрэглэнэ.</p>  <p style="text-align: center;"><i>Зураг 19.(Жишээ зураг)</i></p>	<p style="text-align: center;"><b>Тэрэг</b></p> <p>Цэцэрлэгжүүлэлт ажилд зөөвөрлөх зориулалттай. Өтөг бууц шороо, хог ургамал, талбайн чулуу, хогийг зөөхөд ашиглагдана.</p>  <p style="text-align: center;"><i>Зураг 20.(Жишээ зураг)</i></p>
--	--

### 4.3 Зүлэгт талбайг арчлан хамгаалахад шаардлагатай багаж, хэрэгсэл

4.3.1. Зүлэгт талбайн хог ургамлыг цэвэрлэх, хадах, тэгшлэх, хэлбэржүүлэх зэрэг ажлуудад ашиглагдах багаж хэрэгслүүдийн зориулалтын ерөнхий зааврыг Хүснэгт 3-т оруулав.

*Хүснэгт 3.Зүлэгт талбайг арчлан хамгаалахад шаардлагатай багаж, хэрэгсэл*

Техник хэрэгслийн нэр, ашиглалт	
<p style="text-align: center;"><b>Зэрлэг цавчигч</b></p> <p>Ил талбайн зэрлэгийг цавчиж, хусаж авах зориулалттай. Мөн хөрсийг сийрүүлэх, суллахад хэрэглэнэ.</p>  <p style="text-align: center;"><i>Зураг 21.(Жишээ зураг)</i></p>	<p style="text-align: center;"><b>Үүрдэг хадуур</b></p> <p>Зүлгийг хадах зориулалтаар ашиглана.Хэрэглэхэд хялбар хөнгөн авсаархан.</p>  <p style="text-align: center;"><i>Зураг 22.(Жишээ зураг)</i></p>
<p style="text-align: center;"><b>Зүлэг тэгшлэгч машин</b></p> <p>Зүлэг тэгшлэх, хадах зориулалтаар ашиглана.</p>  <p style="text-align: center;"><i>Зураг 23.(Жишээ зураг)</i></p>	<p style="text-align: center;"><b>Зүлэг тэгшлэгч машин</b></p> <p>Тэгш гадаргуутай талбайн зүлэг тэгшлэх, хадах зориулалтаар ашиглана.</p>  <p style="text-align: center;"><i>Зураг 24.(Жишээ зураг)</i></p>

**Зүлэг тэгшлэгч машин**

Их хэмжээний талбайд зүлэг тэгшлэх, хадах зориулалтаар ашиглана. Талбайд урт хугацаагаар ажиллах боломжтой.



Зураг 25. (Жишээ зураг)

**Гар хадуур**

Өндөр ургасан зэрлэгийг хадаж авах зориулалтаар ашиглана.



Зураг 26. (Жишээ зураг)

**Зүлгийн хайч**

Зүлэгжүүлсэн талбайн ирмэгүүдийг захилах зориулалттай.



Зураг 27. (Жишээ зураг)

**Зүлэг хэлбэржүүлэгч гар хайч**

Хашаа, цэцгийн мандал, модлог ургамлын хослол зохиомжийн ойролцоо ургасан зүлгийг тэгшлэхэд ашиглана.



Зураг 28. (Жишээ зураг)

**Савар**

Зүлэгжүүлэлт, цэцэрлэгийн цэвэрлэгээнд ашиглана.



Зураг 29. (Жишээ зураг)

**РН хэмжигч**

Ус болон хөрсний хүчил шүлтийн орчин (РН), температурыг хэмжинэ.



Зураг 30. (Жишээ зураг)

**Термометр**

Гадна болон дотор агаарын харьцангуй чийгшил хэмжих зориулалттай.



Зураг 31. (Жишээ зураг)



Зураг 32. Үрийг гараар нэгэн жигд цацах (Жишээ зураг)



Зураг 33. Үрийг механизмаар цацах (Жишээ зураг)



Зураг 34. Зүлгийн тайралт, арчилгаа (Жишээ зураг)

#### 4.4 Цэцэгт байгууламжийн арчилгаанд ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд

4.4.1 Цэцэгт байгууламжийн арчилгаанд хөрсийг тармах, тэгшлэх, хөрсийг бутлах, үрслэг шилжүүлэн суулгах зэрэг ажлуудад ашиглагдах багаж хэрэгслүүдийн зориулалтын ерөнхий зааврыг оруулав. MNS 6259: 2011 Ганц наст цэцэг тарих арга стандартын дагуу тарина.

Хүснэгт 4.Цэцэгт байгууламжийн арчилгаанд ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд

Техник хэрэгслийн нэр, ашиглалт	
<p><b>Гар тармуур</b></p> <p>Хөрсийг тармах, тэгшлэх, ургамлын үндсийг бутлах зэрэг олон зориулалтаар ашиглана. Бага орон зайд ашигладаг.</p>  <p>Зураг 35.(Жишээ зураг)</p>	<p><b>Шүдэт гар гапуу</b></p> <p>Хөрсийг бутлах, тэгшлэх, хайрцаг хийх, шан татах, сэндийлэх зэрэг зориулалтаар ашиглана.</p>  <p>Зураг 36.(Жишээ зураг)</p>

**Үрслэг суулгагч**

Бойжуулсан цэцгийн үрслэгийг ил талбайд шилжүүлэн суулгана.



*Зураг 37. (Жишээ зураг)*

**Гар ухуур**

Жижиг гар ухуураар хөрс онгилж, ургамлын суулгац, цэцэг ногооны үрслэг шилжүүлэн суулгах, үндэслэг ургамлыг ухаж авах зэрэгт хэрэглэнэ.



*Зураг 38. (Жишээ зураг)*

**3 шүдэт сийрүүлэгч**

Мөр хооронд тармах, сийрүүлэх, хөрсийг бутлах зориулалттай. Шүдэт мөр гаргагчийг 15, 25, 35, 45, 60 см-ын зайтай өргөн мөрөөр үр суулгахад хэрэглэнэ.



*Зураг 39. (Жишээ зураг)*

**Гар гаануу**

Хөрсийг бутлах, тэгшлэх, хайрцаг хийх, шан татах, сэндийлэх зориулалттай.



*Зураг 40. (Жишээ зураг)*

**Хоовонт хавтан**

Бүх төрлийн цэцгийн үрсэлгээ ургуулах зорилгоор ашиглана.



*Зураг 41. (Жишээ зураг)*

**Бортого**

Бүх төрлийн цэцгийн үрслэг бойжуулж, тарих зориулалтаар ашигладаг.



*Зураг 42. (Жишээ зураг)*

#### 4.5 Мод, сөөгийн тарилтад ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд





4.5.1. Мод сөөгийн суулгацын нүхийг бэлтгэх, суулгахад доорх стандартуудыг мөрдөнө.

Үүнд:

- MNS 6258-1: 2011 Суулгацын нүхийг бэлтгэх, суулгах;
- MNS 6139: 2010 Шилмүүст модны суулгац. Техникийн шаардлага;
- MNS 6141: 2010 Навчит модны суулгац. Техникийн шаардлага;
- MNS6255: 2011 Сөөгийн суулгац. Ерөнхий шаардлага.

4.5.2. Мод, сөөг тарих нүхийг бэлтгэхэд ашиглагдах багаж хэрэгслүүдийн зориулалтын ерөнхий зааврыг орууллаа.

#### Хүснэгт 5.Мод, сөөгийн тарилтад ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд









Техник хэрэгслийн нэр, ашиглалт	
<p><b>Хүрз</b></p> <p>Мод, сөөгийн суулгацыг тарихад ашиглана.</p>  <p><i>Зураг 43.(Жишээ зураг)</i></p>	<p><b>Нүх ухагч</b></p> <p>Мод сөөгийн суулгацын нүх бэлтгэх зориулалттай. Суулгацын төрөл, хэмжээнээс хамааран нүх ухагчийг сонгоно.</p>  <p><i>Зураг 44.(Жишээ зураг)</i></p>
<p><b>Нүх ухагч</b></p> <p>Мод, сөөг тарих нүхийг бэлтгэх зориулалттай.</p>  <p><i>Зураг 45.(Жишээ зураг)</i></p>	<p><b>Нүх ухагч</b></p> <p>Том хэмжээний талбайд мод, сөөг тарих нүхийг бэлтгэх зориулалттай.</p>  <p><i>Зураг 46.(Жишээ зураг)</i></p>

#### 4.6 Мод, сөөгийн арчилгаанд ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд

Мод, сөөгийн титмийн хэсгийг сийрүүлэх, өвчин хортонд өртсөн мөчрийг огтлох, цэвэрлэхэд ашиглагдах багаж хэрэгслүүдийн зориулалтын ерөнхий зааврыг оруулав.



## Хүснэгт 6.Мод, сөөгийн арчилгаанд ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд

Техник хэрэгслийн нэр	Зориулалт, ашиглалтын шаардлага
<p><b>Мөчрийн хайч</b></p>  <p>Зураг 47.(Жишээ зураг)</p>	<p>Мод, сөөгийн мөчрийг огтлох зориулалттай.Мөчрийг залгах, мөчир бэлтгэх, суулгацын үндсийг тайрах, залуу модны титмийг хэлбэржүүлэх, жимслэх мод, сөөгийн таналт тайралтыг хийхэд ашиглана.Мөчрийг хайч нь олон төрөлтэй бөгөөд ажлын зориулалтаас хамааран сонгоно.</p>
 <p>Зураг 48.(Жишээ зураг)</p>	
 <p>Зураг 49.(Жишээ зураг)</p>	
 <p>Зураг 50.(Жишээ зураг)</p>	
 <p>Зураг 51.(Жишээ зураг)</p>	
 <p>Зураг 52.(Жишээ зураг)</p>	
<p><b>Мөчир залгалтын хутга</b></p> <p>Мөчир нахиа залгах зориулалттай. Эгц шулуун иртэй, хутганы ирний эсрэг талын үзүүрт мөчир нахиаг залгахаар зүссэн холтсыг хөндийрүүлж өгөх үүрэг зориулалтаар ашигладаг.</p>  <p>Зураг 53.(Жишээ зураг)</p>	<p><b>Мөчир залгалтын хутга</b></p> <p>Нахиа залгахын өмнө шилбийг цэвэрлэх, бүдүүрч томорсон найлзуур, шинэ залуу өргөслөг мөчир, өрсөлдөгч мөчир болон бусад мөчир салааг тасалж танах, ишинд хэрчлээс ховил гаргахын өмнө орчин тойрных нь шарх сорви гэх мэтийг арилгаж цэвэрлэх, шархыг эмчлэх зэрэгт өргөн хэрэглэдэг.</p>  <p>Зураг 54.(Жишээ зураг)</p>

### Цэцэрлэгийн хөрөө

Энэ хөрөөг дотор нь татуургатай, татуургагүй гэж ангилна. Эвхдэг хөрөөгөөр хөрөөдөх боломжгүй мөчрийг сийрүүлэх, хэт хурц өнцгөөр байрласан мөчир гишүү зэргийг огтолж тайрахад ашиглана. Цэцэрлэгийн хөрөөнүүдийн шүд нь эгц, налуу гэсэн байрлалтай байна.



Зураг 55. (Жишээ зураг)

### Мөчир огтлогч

Мод, сөөгийн титмийн дээд хэсгийн мөчрийг огтлох зориулалттай. Мод, сөөгийн титмийн дээд талын гар хүрэхгүй мөчир гишүү тусгай шат хэрэглэхгүйгээр огтолж танахад ашиглана.



Зураг 56. (Жишээ зураг)

### Мөчир огтлох цахилгаан хөрөө

Мод бут, мөчир тайрах, тэгшлэх зориулалтаар ашигладаг.



Зураг 57. (Жишээ зураг)

### Шат

Мод, сөөгийн мөчир тайрахад зориулагдсан. Эвхэгддэг А хэлбэртэй, шулуун суудаг шат зэрэг олон төрөл байдаг.



Зураг 58. (Жишээ зураг)

## 4.7 Мод, сөөгийн хэлбэржүүлэлтэнд ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд

4.7.1. Мод, сөөгийг хэлбэржүүлэхдээ MNS 6772:2019 Мод сөөгийг хэлбэржүүлэх техникийн шаардлагыг дагаж мөрдөнө.

4.7.2. Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн мод, сөөгийг хэлбэржүүлэхэд ашиглах багаж, тоног төхөөрөмжийн зориулалт, ашиглалт, хэрэглэх үеийн аюулгүй ажиллагаанд UCS 0802A:2022 дагаж мөрдөнө

## Хүснэгт 7.Мод, бут сөөгийн хэлбэржүүлэлтэд ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд

Техник хэрэгслийн нэр	Зориулалт, ашиглалтын шаардлага
<p><b>Хэлбэржүүлэгч хөрөө</b></p>  <p><i>Зураг 59.(Жишээ зураг)</i></p>	<p>Мод, сөөгийн титмийн оройн хэсгийг хэлбэржүүлэх зориулалттай.Мод сөөгийн хэлбэржүүлэлтийн зориулалтаас хамаарч, сольж хэрэглэх боломжтой багаж.</p>
<p><b>Хэлбэржүүлэгч хөрөө</b></p>  <p><i>Зураг 60.(Жишээ зураг)</i></p>	
<p><b>Хэлбэржүүлэгч хөрөө</b></p>  <p><i>Зураг 61.(Жишээ зураг)</i></p>	<p>Ногоон хана, таримал хашлага, эмжээр хэлбэржүүлэх зориулалттай.Үйлдвэрлэгчийн зааврыг дагуу ашиглана</p>
<p><b>Хэлбэржүүлэгч хөрөө</b></p>  <p><i>Зураг 62.(Жишээ зураг)</i></p>	
<p><b>Мөчир огтлогч</b></p> <p>Мод, сөөгийг хэлбэржүүлэн засах зориулалттай. Цэвэрлэгээний, сийрүүлэх, залуужуулах огтлолд ашиглагдана.</p>  <p><i>Зураг 63.(Жишээ зураг)</i></p>	<p><b>Хэлбэржүүлэх хайч</b></p> <p>Ногоон хана, таримал хашлага, эмжээр хэлбэржүүлэх зориулалттай.</p>  <p><i>Зураг 64.(Жишээ зураг)</i></p>

### Хэлбэржүүлэгч хайч

Цэвэрлэгээний, сийрүүлэх, залуужуулах, хэлбэржүүлэх огтлолд ашиглагдана.



Зураг 65. (Жишээ зураг)

### Бүхээгтэй кран

Мод, сөөгийн хэлбэржүүлэлтэд ашиглагдана



Зураг 66. (Жишээ зураг)



### Хэлбэржүүлэгч хөрөө

Нэгэн жигд хэлбэржүүлэх, өндрийн тохируулагчтай таримал хашлага, хана хэлбэржүүлэхэд ашиглагдана

Зураг 67. (Жишээ зураг)



Зураг 68. Мод, сөөгийг хэлбэржүүлэх (Жишээ зураг)

#### 4.8. Мод, сөөгийг шилжүүлэн суулгахад ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд

- 4.8.1. Мод, сөөгийг шилжүүлэн суулгахдаа MNS 6773:2019 Сөөгийн суулгацыг шилжүүлэн суулгах, арчлах техникийн шаардлага, MNS 6774:2019 Том мод суулгацыг шилжүүлэн суулгах, арчлах стандартыг мөрдөнө.
- 4.8.2. Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтэд мод, сөөгийг шилжүүлэн суулгахад ашиглах багаж, тоног төхөөрөмжийн зориулалт, ашиглалтын ерөнхий заавар оруулав.

#### Хүснэгт 8.Мод, бут сөөгийн шилжүүлэн суулгахад ашиглагдах багаж, тоног төхөөрөмжүүд

Техник хэрэгслийн нэр, ашиглалт	
<p><b>Шилжүүлэн суулгагч</b></p> <p>Мод, сөөгийг шилжүүлэн суулгахад зориулагдсан.Дунд зэргийн өндөртэй мод, сөөгийг шилжүүлэн суулгахад ашиглагдана.</p>  <p><i>Зураг 69.(Жишээ зураг)</i></p>	<p><b>Дунд оврын шилжүүлэн суулгагч</b></p> <p>Мод, сөөгийг шилжүүлэн суулгахад зориулагдсан дунд оврын ачаатай шилжүүлэн суулгагч.Том хэмжээний мод, сөөгийг шилжүүлэн суулгахад ашиглагдана.</p>  <p><i>Зураг 70.(Жишээ зураг)</i></p>
<p><b>Том оврын шилжүүлэн суулгагч</b></p> <p>Мод, сөөгийг шилжүүлэн суулгахад зориулагдсан том оврын ачаатайшилжүүлэн суулгагч.</p>  <p><i>Зураг 71.(Жишээ зураг)</i></p>	<p><b>Өргөгч машин</b></p> <p>Мод сөөгийг өргөж, ачиж буулгах зориулалттай машин.</p>  <p><i>Зураг 72.(Жишээ зураг)</i></p>

### Өргөгч кран

Том модыг өргөх, шилжүүлэн тарихад ашиглагдана.



Зураг 73. (Жишээ зураг)

### Титэм баглагч

Том модыг шилжүүлэх, зөөж тээвэрлэхэд модны титмийн хэсгийг боож, баглах зориулалттай машин.



Зураг 74. (Жишээ зураг)

## 4.9 Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтэд ашиглагдах усалгааны тоног төхөөрөмжүүд, машин механизм


4.9.1. Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтэд ашиглах багаж тоног төхөөрөмжийн жагсаалтыг хүснэгт 9-т харуулав.

*Хүснэгт 9. Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтэд ашиглагдах усалгааны тоног төхөөрөмжүүд, машин механизм*

### Техник хэрэгслийн нэр, ашиглалт

#### Дуслын усалгааны систем

Мод, сөөгт зориулсан дуслын усалгааны систем бөгөөд усны хэрэгцээг хангах зорилгоор хэрэглэнэ.



Зураг 75. (Жишээ зураг)

#### Бороожуулагч

Зүлгийн усалгаанд зориулагдсан төхөөрөмж.



Зураг 76. (Жишээ зураг)

**Бага оврын бороожуулагч**

Бага хэмжээний зүлгийн талбайд хэрэглэнэ.



Зураг 77. (Жишээ зураг)

**Усны нөөцлийн сав**

Зүлэгжүүлсэн талбайг услах усыг нөөцлөх зориулалтаар ашиглана.



Зураг 78. (Жишээ зураг)

**Гар шүршүүр**

Крантны ус, даралттай усны үүсвэрт холбож, зүлэг, цэцэг тарих талбайг услах зорилгоор ашиглана.



Зураг 79. (Жишээ зураг)

**Цахигаан мотор ба гар насос**

Хувин саваар ус зөөж зүлэг цэцэг улсах ажлыг хөнгөвчлөхийн тулд худаг, голоос ус сорж, татах зорилгоор зөөврийн цахилгаан мотор, эсхүл ус сорж татах насос зэргийг ашигладаг.



Зураг 80. (Жишээ зураг)

**Услуур (шүршүүр)**

Цэцгийн мандал, цэцгийн үрэслэгээ услах зориулалттай. Цэцэг болон хүлэмжинд таригдсан үр, үрслэгийг шүршиж услахад тусгай цоргот шүршүүртэй, төмөр буюу нийлэг эдээр хийгдсэн хувинг хэрэглэнэ.



Зураг 81. (Жишээ зураг)

**Зөөврийн мотор**

Мод, сөөгийн усалгааг зөөврийн аргаар услахад ашиглагдана.







Зураг 82. (Жишээ зураг)

## 4.10 Ногоон байгууламжийн өвчин, хортонтой тэмцэхэд ашиглагдах багаж, хэрэгсэл

### 4.10.1. Ногоон байгууламжийн өвчин хортонтой тэмцэхэд ашиглах багаж хэрэгслийн ерөнхий зааврыг хүснэгт 10-г оруулав

*Хүснэгт 10. Ногоон байгууламжийн өвчин хортонтой тэмцэхэд ашиглагдах багаж, хэрэгсэл*

<b>Техник хэрэгслийн нэр, ашиглалт</b>	
<p style="text-align: center;"><b>Хор цацагч</b></p> <p>Хортон шавж устгах, хог ургамлын тархалтыг бууруулах зориулалттай. Мөр хоорондын боловсруулалтын, үр ариутгагч, үйлчлэлээр нь хуурай байдлаар пургих, шингэн байдлаар шүрших, хагас хуурай байдлаар үрийн гадаргууд наалдуулах зэргээр ашиглана.</p>  <p style="text-align: center;"><i>Зураг 83. (Жишээ зураг)</i></p>	<p style="text-align: center;"><b>Үүрдэг хор цацагч</b></p> <p>Ургамал хамгаалах бодис шүрших зориулалтаар ашиглана. Бага хэмжээний талбайн цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжид хэрэглэдэг. Талбайн бүх хэсгүүдэд цацах даралт, шингэний найрлага, цацах норм жигд, ижил байх ёстой. Ингэж жигд цацахад алхалтын хурд хамгийн их нөлөөлнө гэдгийг анхаарах хэрэгтэй.</p>  <p style="text-align: center;"><i>Зураг 84. (Жишээ зураг)</i></p>
<p style="text-align: center;"><b>Үүрдэг хор цацагч</b></p> <p>Даралтат сав бүхий цацах төхөөрөмж. Таримлын төрөл болон өндрөөс хамаарч ургамал хамгааллын бодисыг янз бүрийн нормоор цацах шаардлагатай.</p>  <p style="text-align: center;"><i>Зураг 85. (Жишээ зураг)</i></p>	<p style="text-align: center;"><b>Шавж наалдуулагч цавуутай наалт</b></p> <p>Шавжийг өөртөө татан наалдуулах замаар хортон шавжтай тэмцэх зориулалтаар ашигладаг. Шавжийн тооны хэт олшрол явагдаж байгааг тогтоосны дараа тэмцэх аргыг явуулна. Шавжийг өнгөөр даллан дуудаж урхидахад зориулагдсан. Хоёр талдаа, эсхүл нэг талдаа наалдуулах цавуутай. Хортон шавжийн гаралт, нягтшил, тооны хөдлөл зүйг хянах, тоо толгойг устгахад хэрэглэнэ.</p>  <p style="text-align: center;"><i>Зураг 86. (Жишээ зураг)</i></p>



## АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- “Ойд арчилгаа хийх тухай” Улаанбаатар 2012 он
- “Ойн мэргэжлийн ажилтан” гарын авлага
- Нинж .Б. “Жимсний аж ахуйн дадлага” 2014 он
- Нинж Б.” Жимс, жимсгэнэ тариалалт боловсруулалт” гарын авлага 2015 он
- Нинж Б. “Цэцэрлэгжүүлэлт, цэцгийн аж ахуйн дадлага”, Улаанбаатар 2012
- Цогтоо Я., Банзрагч ц., Ганбаатар Ч., “Ойн аж ахуйн механикжсан технологи”, Улаанбаатар 2014 он
- Forestry suppliers, CATALOG-67, 2016
- Ургамал хамгаалах цогц арга, ургамал хамгааллын бодисын хэрэглээ-2019
- MNS 4969:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгаа
- MNS 6139:2010 Шилмүүст төрлийн модны суулгац. Техникийн шаардлага
- MNS 6141:2010 Навчит төрлийн модны суулгац. Техникийн шаардлага
- MNS 2418:2011 Мод үржүүлгийн газрын хөрсийг боловсруулах, Ерөнхий шаардлага
- MNS 6253-1:2011 Мод сөөгийн үрийг тарихад бэлтгэх, Ерөнхий шаардлага
- MNS 6253-2:2011 Мод сөөгийн үр тарих Ерөнхий шаардлага
- MNS 6253:2011 Мод сөөгийн үр тарьсны дараа арчлах. Ерөнхий шаардлага
- MNS 6254:2011 Мод сөөгийн суулгацыг бойжуулах, Ерөнхий шаардлага
- MNS 6256:2011 Сөөгөнцрийн суулгац. Ерөнхий шаардлага
- MNS 6257:2011 Улиасны суулгац. Ерөнхий шаардлага
- MNS 6258-1:2011 Суулгацын нүхийг бэлтгэх, суулгах. Ерөнхий шаардлага
- MNS 6258-2:2011 Мод сөөгийн суулгац арчлах
- MNS 6259:2011 Ганц наст цэцэг тарих арга
- MNS 6260:2011 Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах
- MNS 6772:2019 Мод сөөгийг хэлбэржүүлэх. Техникийн шаардлага
- MNS 6773:2019 Сөөгийн суулгацыг шилжүүлэн суулгах, арчлах Техникийн шаардлага
- MNS 6774:2019 Том мод, суулгацыг шилжүүлэн суулгах, арчлах
- GB/T 6866-2008 (БНХАУ-ын стандарт)
- GB 6866-86 (БНХАУ-ын стандарт)
- MNS ISO 13688:2000 Ажлын тусгай хувцас – ерөнхий шаардлага
- MNS 5622-2006 Гарын хамгаалалт /бээлий/
- MNS 5623-2006 Хөлийн хамгаалалт ажлын тусгай гутал
- MNS 5621-2006 Толгой хамгаалах хэрэгсэл дуулга
- MNS 4931-2000 Хөдөлмөрийн хамгааллын хэрэгсэлд тавих ерөнхий шаардлага
- MNS 13688-2000 Ажлын тусгай хувцас ерөнхий шаардлага
- <https://estandard.gov.mn/>
- <https://mofa.gov.mn/exp/>
- <https://www.mlsp.gov.mn/>
- <https://www.doczhi.com/p-380848.html>

## ТЭМДЭГЛЭЛ

Blank page with horizontal dotted lines for writing.





Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг  
ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР



Хан-Уул дүүрэг, 23-р хороо, 17100, Наадамчдын зам  
1200, Нутгийн захиргааны цогцолбор байр.



70118030, 70118040



[www.standard.ub.gov.mn](http://www.standard.ub.gov.mn)



Хотын стандарт, хяналтын газар